



ТОЧНОСТ

БАРИЛГЫН ТӨСӨВ ЗОХИОГЧ ПРОГРАМ

Энэхүү барилгын төсөв зохиогч програм нь Барилгын зөвлөх үйлчилгээний компани “Нормчлол” ХХК, програм хангамж үйлдвэрлэх чиглэлээр мэргэшсэн компани “Супер Ассист Системс” ХХК –уудын хамтарсан бүтээл бөгөөд өмнөх ижил төстэй Барилгын төсвийн програмуудын дутагдалтай талуудыг арилгаж, нэмэлт шинэ боломжуудыг оруулж ирэх, барилгын төсвийг бодитой зохиох, хөрөнгө оруулагчид түүнийг хэрэглжүүлэгч талуудад шаардлагатай төсвүүдийг иж бүрнээр нь гаргах үндсэн зорилготой хөгжүүлэгдсэн програм юм.

Энэхүү програм нь өнөөдөр мөрдөгдөж байгаа төсвийн суурь нормуудыг ашиглаж нөөцийн аргаар төсөв зохиох үндсэн аргыг програмчлах бөгөөд төсөв зохиож байгаа төсөвчдийн механик ажлыг хөнгөвчлөх, цаг хугацааг хэмнэх, төсвийн тооцоог алдаагүй болгох, чанарыг сайжруулах, барилгын удирдлага, инженер, техникийн ажилтнуудыг мэдээллээр хангах, үйлдвэрлэлийн явцад хяналт хийх боломжийг бүрдүүлэх үндсэн шаардлагуудыг тусгасан. Програмын өгөгдлийн санд одоогоор мөрдөгдөж байгаа нийт төсвийн суурь нормууд, түүний нэмэлтүүдийг иж бүрэн байдлаар оруулсан. Баазад орсон төсвийн суурь нормуудын эмхэтгэл болон нэмэлтүүдийн жагсаалтыг хавсралтаар үзүүлэв.

Програмыг зохиохдоо Зам, Тээвэр, Барилга Хот Байгуулалтын сайдын 2012 оны 181-р тушаалаар батлагдсан “Төсөв зохиох дүрэм” -д орсон төсвийн тооцоо болон төсөв зохиох нийт маягтуудыг автоматаар тооцохоор програмыг боловсруулсан. Мөн дээрх төсөв зохиох зааварт ороогүй хоёр маягтаар ажил нэг бүрээр болон үе шатаар ажлын төсөв зохиохоор програмчилсан. Програмын өгөгдлийн санд барилгын материалуудын хэмжих нэгж, цэвэр жинг бохир жинд шилжүүлэх итгэлцүүрүүдийг материалын нэр, төрөл, марк бүрээр нарийвчлан гаргасан учир тээврийн тооцоог үнэн зөв хийх боломжийг бүрдүүлсэн гэж үзэж байна. Мөн төсвийн суурь нормын хөдөлмөр зарцуулалт, материалын орц, машин цагийн тоо зэрэг үзүүлэлтийг батлагдсан нормтой тохируулах ажлыг нарийвчлан хийж програмын өгөгдлийн сангын нарийвчлал, чанаржилтыг сайжруулсан програм болж чадсан.

ПРОГРАМЫН ДАВУУ ТАЛУУД

Програмын хувьд барилгын төсөв зохиоход шаардлагатай бүхий л үйлдлүүдийг оруулсан бөгөөд ижил төстэй барилгын төсвийн програмуудаас давуутай талуудыг дараах байдлаар жагсааж болно. Үүнд:

- Шинэ дүрэмд байгаа маягтуудаар, төсвүүдийг автоматаар тооцож, хэвлэн гаргаж чаддаг болсон. Тухайлбал : Обектийн төсөв, Нэгдсэн төсвийн товчоог автомат болгож, улмаар маягтаар гаргадаг болгов.

- Материал, машин цаг, тээврийн тооцоог ажил нэг бүр, үе шат бүрээр, нийт барилгаар гаргаж, үзүүлэлтийг балансжуулдаг болгов.
- Барилгын төсвийн ижил үйлдэлтэй програмуудад элбэг гардаг алдаа болох анх батлагдсан төсвийн суурь нормоор өгөгдлийн сан үүсгэхэд гаргасан алдаанаас төсвийн үнэ өндөр гардаг алдааг илрүүлэн, засваруудыг хийсэн.
- Төсвийн суурь нормын ажлын бүтэц, хөдөлмөр зарцуулалт, материалын орц, машин цагийн лавлахыг иж бүрнээр нь програмын үндсэн дэлгэцэнд байнга харагддаг болгосон.
- Барилгын төсөв зохиож байхад тохижилтын төсвийг авто замын эмхэтгэлээс авч байсныг барилгын суурь нормын хэлбэрт оруулж шууд төсөв зохиох боломжийг бүрдүүлсэн
- Төсөв зохиох үйл ажиллагаа хялбар болгох, хийгдэх үйлдүүдийг хурдан болгох, алдаа гарахгүй болгох тал дээр ажилласан.
- Манай төсвийн програмаар зохиосон төсвийн тооцоог эхнээс нь дуустал хянах, шалгах өргөн боломж нээгдсэн бөгөөд, авилгажсан, өндөр үнэтэй төсөв гарах боломжийг бүрэн хаасан.
- Барилгын төсөв хянах, шалгах, санхүүжүүлэхэд тодорхой мэдэгдэхүйц өөрчлөлт гарахаар болсон.
- Програмын нууцлал сайжирч, програмыг компьютерт суулгахад бүртгэлтэй кодоор идэвхжүүлдэг болсон. Мөн програмд гарсан өөрчлөлт, сайжруулалтуудыг хэрэглэгч өөрөө хийх боломжтой болгосон.
- Програмыг хөгжүүлэхдээ орчин үеийн хамгийн дэвшилтэд технологиудыг ашигласан.

ПРОГРАМ ХӨГЖҮҮЛСЭН БАГ

Програмын үндсэн зөвлөхөөр 1969 оноос өнөөг хүртэл Барилгын норм, норматив боловсруулах чиглэлээр ажиллаж байгаа, өмнө гарсан төсөв зохиох хоёр програмд зөвлөхөөр ажилласан зөвлөх эдийн засагч, “Нормчлол” ХХК –захирал Ширчин овогтой Цэвэлрагчаа (Төсвийн нормативын бааз БНБД -4 хэсгийг удирдан боловсруулсан /1989/, Төсвийн суурь нормын эмхэтгэлүүд, түүний дүрмүүд /2006/, Ажлын тоо хэмжээ бодох арагчлал , Төсвийн томсгосон нормын үнэлгээ /2011/) ажиллаж байгаа болно.

Хөгжүүлэгч компаниар програм хангамж үйлдвэрлэх чиглэлээр мэргэшсэн компани “Супер Ассист Системс” ХХК ажиллаж байна. “Супер Ассист Системс” ХХК нь барилгын салбарын програм хангамж дагнан хөгжүүлдэг бөгөөд дараах бүтээгдэхүүн, үйлчилгээг барилгын салбарт хийгээд байгаа юм. Үүнд: Барилгын томсгосон төсвийн норм зохиох ажлыг автоматжуулах програм, Барилгын хашлага бүтээцийн дулаан техникийн тооцооны програм зэрэг бүтээгдэхүүнийг дурдаж болно.

СИСТЕМИЙН ШААРДЛАГА

“ТОЧНОСТ” Барилгын төсөв зохиогч програмыг компьютерт суулгахад дараах тоног төхөөрөмж, програм хангамж шаардлагатай.

Үүнд :

- Pentium Duo Core (512М –аас их хэмжээтэй санах ойтой) болон түүнээс дээш хурдтай компьютер

- Windows XP (32 болон 64 bit –ийн үйлдлийн системүүд) болон түүнээс дээш хувилбарын үйлдлийн систем
- Microsoft .NET Framework 3.0 болон түүнээс дээш хувилбар
- Дэлгэцний нарийвчлал 1024 x 768 –аас их байх шаардлагатай
- PDF форматтай файл уншигч (Adobe reader, Foxit reader гэх мэт...) суусан байх

Өгөгдөлийн санд орсон ажилууд

ХАВСРАЛТ

БАРИЛГА УГСРАЛТ	
БНбД-81-01-06	Газрын ажил
БНбД-81-03-06	Өрөмдлөгө тэсэлгээний ажил
БНбД-81-05-06	Гадсан суурийн ажил
БНбД-81-06-06	Бетон ба төмөр бетон цутгамал бүтээцүүдийн ажил
БНбД-81-07-06	Бетон ба төмөр бетон угсармал бүтээцүүдийн ажил
БНбД-81-08-06	Тоосгон ба гулдмай бүтээцийн ажил
БНбД-81-09-06	Төмөр бүтээцийн ажил
БНбД-81-10-06	Модон бүтээцийн ажил
БНбД-81-11-06	Шалны ажил
БНбД-81-12-06	Дээврийн ажил
БНбД-81-13-06	Барилгын бүтээц ба тоног төхөөрөмжийг зэврэлтээс хамгаалах ажил
БНбД-81-14-06	Хөдөө аж ахуйн барилгад хэрэглэгдэх бүтээцүүдийн ажил
БНбД-81-15-06	Засал, чимэглэлийн ажил
БНбД-81-24-06	Дулаан тусгаарлалтын ажил
БНбД-81-34-06	Үйлдвэрийн зуух яндангийн ажил
БНбД-81-35-06	Барилга байгууламжийн шинэчлэлтийн ажил
БНбД-81-37-06	Зүлэгжүүлэлт, ой хамгаалах зурвасын ажил
БНбД 81-92-12	Лифтний угсралтын ажлын төсвийн суурь норм (шинээр батлагдсан)
САНТЕХНИКИЙН АЖЛЫН УГСРАЛТ	
БНбД-81-16-06	Дотор цэвэр усны ажил
БНбД-81-17-06	Дотор бохир усны ажил
БНбД-81-18-06	Дотор халаалтын ажил
БНбД-81-19-06	Салхижуулалт-агаар сэлгэлтийн ажил
БНбД-81-21-06	Гадна цэвэр усны ажил
БНбД-81-22-06	Гадна бохир усны ажил
БНбД-81-23-06	Гадна дулаан хангамжийн ажил
ЦАХИЛГААН АЖЛЫН УГСРАЛТ, БАРИЛГЫН ХОЛБООЖУУЛАЛТ	
БНбД-81-20-04	Орон сууц олон нийтийн барилгын цахилгаан гэрэлтүүлгийн ажил
БНбД-81-30-04	Барилгын цахилгаан дамжуулах шугамын ажил
БНбД-81-38-04	Үйлдвэрийн барилгын цахилгаан угсралтын ажил
БНбД-81-39-04	Хянах хэмжих хэрэгсэл ба автомат төхөөрөмжийн ажил
БНбД-81-40-04	Барилгын холбоожуулалтын ажил
БНбД 81-31-12	Холбоо, радио, телевизийн байгууламжийн барилга
БНбД 81-40-04*/12	угсралтын ажлын төсвийн суурь норм (шинээр батлагдсан) Барилгын холбоожуулалтын ажлын төсвийн суурь нормын нэмэлт (шинээр батлагдсан)

БАРИЛГА ЗАСВАР	
БНбД-81-50-05 БНбД-81-51-05 БНбД-81-52-05 БНбД-81-53-05 БНбД-81-54-05	Газар шороо, суурийн ажил Хана, хамар ханын ажил Хучилтын ажил Шалны ажил Дээврийн ажил
БНбД-81-55-05 БНбД-81-56-05 БНбД-81-57-05 БНбД-81-58-05 БНбД-81-59-05 БНбД-81-60-05 БНбД-81-61-05 БНбД-81-62-05 БНбД-81-63-05 БНбД-81-64-05 БНбД-81-65-05 БНбД-81-70-05 БНбД 81-93-12	Хаала, цонхны ажил Шат, довжоо, пийшингийн ажил Засал, чимэглэлийн ажил Угсармал төмөр бетоны ажил Тохижилт, бусад ажил Тогоо, ус халаагч, зангилгааны ажил Цэвэр ус, дулааны шугам хоолойн ажил Халаах хэрэгслийн ажил Салхивчийн ажил Бохир усны шугам, хоолойн ажил Нүх цоолох, ховил гаргах ажил Цахилгаан угсралтын ажил Лифтний их засварын ажлын төсвийн суурь норм
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД	
БНбД-81-02-03 БНбД-81-02-06 БНбД-81-02-08 БНбД-81-02-12	Барилга, сантехникийн ажлын нэмэлт №1 Барилга, сантехник, цахилгааны ажлын нэмэлт №2 Барилга, сантехник, цахилгааны ажлын нэмэлт №3 Барилга, сантехникийн ажлуудын нэмэлт №4 (шинээр батлагдсан) 2007 онд батлагдсан Авто замын барилгын төсвийн жишиг нормын барилга угсралтын ажилтай холбоотой хэсэг (Барилга угсралтын ажилд мөрдөгдөж буй арга зүйгээр тооцсон)

ХОЛБОО БАРИХ



Компанийн нэр: СУПЕР АССИСТ СИСТЕМС ХХК

Вэб хаяг : <http://www.super-assist.com>

Имэйл хаяг : info@super-assist.com

Харилцах утас : 98994541, 98974541

**Хаяг : Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Төв шуудангийн баруун талд,
Экспрес цамхаг, 301 тоот**

Зөвлөх компанийн нэр: НОРМЧЛОЛ ХХК

Харилцах утас : 99736371